



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 3.2.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны биелэлт, үр ашиг, санхүүгийн гүйцэтгэл, хөдөлмөр хамгаалал, байгаль орчны үзүүлэлтээр үнэлж, нийт 80.1 хувийн гүйцэтгэлтэй буюу “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

2. Компанийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг өсгөх чиглэлээр тодорхой арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Т.Отгонболд) нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Ц.ЗОРИГТБАТ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн
Талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 3.2.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК нь 2025 онд 268.2 тэрбум төгрөгийн орлого олж, 1.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдлыг бууруулсан, нүүрсний тарифын хязгаарлалтын улмаас үүссэн өр төлбөрийг барагдуулах, компанийн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, мөн Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайланг харгалзан үзэж, Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

2. Компанийн 2025 оны аудитын тайланд дурдсан акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаатай төлөвлөгөө боловсруулан бүрэн хэрэгжүүлж, цаашид ижил төрлийн алдаа, зөрчил давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Т.Отгонболд) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЗОРИГТБАТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн өр төлбөрийг шийдвэрлэх асуудлыг
нэмэлтээр судалж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлаар хэлэлцүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 3.2.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн өр төлбөрийг хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах, өрийн бүтцийг өөрчлөх болон бусад боломжит хувилбараар шийдвэрлэх асуудлыг компанийн санхүүгийн чадавх, зах зээлийн нөхцөл байдал, хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн нэмэлтээр судалж, санал боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус даалгасугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан асуудлаар компанийн санхүү, хууль эрх зүй, эдийн засгийн тооцоо судалгаа хийж, шаардлагатай материал, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Т.Отгонболд)-д үүрэг болгосугай.

3. Компанийн хөрөнгө, бизнесийн үнэ цэнэ, хувьцааны үнэлгээ болон өрийг хувьцаагаар солих тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхолд үзүүлэх нөлөөллийн талаар хараат бус мэргэшсэн байгууллагаар дүгнэлт, үнэлгээ гаргуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

4. Жижиг хувьцаа эзэмшигчид болон нийт хувьцаа эзэмшигчдэд холбогдох мэдээллийг тэгш, ил тод хүргэж, санал авах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Т.Отгонболд) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолд заасан ажлын үр дүн, санал дүгнэлт, үнэлгээ, тооцоо судалгаанд үндэслэн компанийн өр төлбөрийг шийдвэрлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дахин хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуульд заасан хугацаа, журмын дагуу зарлан хуралдуулж, хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг урьдчилан хүргэх ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Ц.ЗОРИГТБАТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах
тухай асуудлыг хойшлуулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 3.2.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн өр төлбөрийг хувьцаагаар солих асуудлыг нэмэлтээр судалж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Багануур” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэхгүй байхаар тогтоосугай.

2. Компанийн өр төлбөрийг шийдвэрлэх асуудлаар хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарсны дараа шаардлагатай тохиолдолд компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хууль тогтоомжийн дагуу боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

3. Энэхүү тогтоолтой холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хуульд заасан журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЗОРИГТБАТ



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт “Багануур” ХК-ийн дүрмийн 3.2.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 08, 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгосугай:

1. Б.Батцэцэг
2. Э.Дөлгөөн
3. Б.Баярдаваа
4. Г.Намчинсүрэн
5. Д.Жавзансүрэн
6. П.Баттөр
7. Э.Шижир
8. М.Отгонбаяр

2. Компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдал, стратегийн хэрэгжилт, засаглалын тогтвортой байдлыг хангах үүднээс хараат бус гишүүдийг дараагийн хугацаанд улираан сонгох талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг улируулан сонгосугай:

1. Н.Зоригтсайхан
2. Ө.Гэрэлт-Од
3. Д.Энхжаргал
4. С.Цолмон
5. Б.Даваатогтох

3. Сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх нь Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хугацаагаар хүчинтэй байхаар тогтоосугай.

4. Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд эрх бүхий байгууллагаас хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болох нь тогтоогдсон өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЗОРИГТБАТ